

## БАЯНДЭЛГЭР СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАХ ХАМГААЛАХ ЖУРАМ

### Нэг. Зорилго:

Сумын нутаг дэвсгэрт ус бэлчээр ашиглах, өвөлжөө хаваржаа эзэмших, мал оторлох, хадлан тэжээл бэлтгэхэд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

### Хоёр. Удирдлага зохион байгуулалт:

2.1. Нөөц нутаг ус бэлчээр ашиглах, өвөлжөө хаваржаа эзэмших, мал оторлох, хадлан тэжээл бэлтгэх тухай асуудлыг энэ журамд заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурал, засаг даргын саналыг үндэслэн Сумын засаг дарга шийдвэрлэнэ.

### Гурав. Бэлчээр ашиглах нийтлэг журам:

3.1. Бэлчээр ашиглах, өвөлжөө хаваржаа эзэмших зөвшөөрлийг багийн засаг даргын саналыг үндэслэн сумын засаг дарга олгоно.

3.2. Сумын нутагт гадны харьяат малчид, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад өвөлжөө хаваржааны газар эзэмшүүлэхгүй бөгөөд өөрийн сумын малчдын хотонд болон бэлчээр нутагт өвөлжиж хаваржиж буй өөр сумын иргэдээс “Газрын төлбөрийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 2 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоолоор батлагдсан “Сумын газрын үнэлгээ, төлбөрийн бүсийн хил зааг, төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоо тухай” тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуубэлчээрийн төлбөр авна. Бэлчээрийн төлбөр нь Хэнтийн төв хэсгийн тайгын тойрог /Х8/-т 175 төгрөг, Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог /Х9/-т 1 хонин толгойд 270 төгрөг байна

Малын тоо толгойг хонин толгойд шилжүүлэхдээ “Газрын төлбөрийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу тэмээг 5, Адуу 6, Үхэр 6, Ямаа 0.9 гэсэн итгэлцүүрээр тооцно.

3.3. Өвөлжөө хаваржааны зориулалтаар газар эзэмшигч нь тухайн газраа өөрөө эзэмшилгүй 2 жил болох, бусдад худалдах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан нөхцлийн дагуу 2 жил дараалан ашиглаагүй буюу өөр сум дүүргийн малчдад эзэмшүүлэх зэргээр газар эдэмшүүлэх гэрээний нөхцөл болзлыг зөрчсөн тохиолдолд “Газрын тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.6-д заасны дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг Сумын засаг дарга хүчингүй болгоно.

3.4. Өвөлжөө хаваржааны зориулалтаар газар эзэмших хүсэлт гаргасан, суманд шилжиж ирээд нэгээс доошгүй жил болсон, 100-аас доошгүй малаа суманд тоолуулсан иргэнд багийн засаг даргын тодорхойлолтыг үндэслэн сумын засаг дарга захирамж гаргаж газар эзэмшүүлнэ.

3.5. Өөрийн өвөлжөө хаваржаагаа бусдад зөвшөөрөлгүй шилжүүлсэн, худалдсан тохиолдолд дахин өвөлжөө хаваржааны газар олгохгүй.

**Дөрөв. Нөөц нутгийн бэлчээр ашиглалт:**

4.1. Бэлчээрийг зөв зохистой ашиглах зорилгоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр сумын бэлчээрийн нөөц нутаг болгосон Байдлаг багийн Галттай Булнай, Галуут багийн Ламын уул орчмын өвөлжөө хаваржааг 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1-нийг хүртэл чөлөөлж ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх

4.2. Шаардлагатай тохиолдолд мал оруулах болон бэлчээр чөлөөлөх хугацааг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэн өөрчилж болно.

4.3. Нөөц нутагт өвөлжих малын тоог багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.3. Тогтоосон малын тооны хязгаарт багтаан нөөц нутагт бэлчээр ашиглуулах ажлыг багийн засаг дарга зохион байгуулж гүйцэтгэнэ.

4.4. Нөөц нутагт багийн засаг даргын зөвшөөрлөөр зохион байгуулалттайгаар хадлан бэлтгэж болно.

4.5. Нөөц нутагт өвөлжиж хаваржих малчид малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээнд бүрэн хамруулсан байна.

4.6. Нөөц нутагт адууг суурилан оруулахгүй.

**Тав. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага:**

5.1. “Зөрчлийн тухай хууль”-ийн 8 дугаар бүлгийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн “... хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.

**Баяндэлгэрсумын**

**Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал**